АЛТАЙ ЗАМ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Огноо:	**2026.10.06**	
Эхэлсэн цаг:	**14:00**	
Дууссан цаг	**15:00**	
Хаана:	**Улаанбаатар хот. ХУД 23-р хороо, "Алтайн Зам" ХК – ийн хурлын танхим**	
Хурлын төрөл:	☐ Ээлжит хурал	☒ **Ээлжит бус хурал**
Дугаар:		

Хурлын ирц

1	М.Нямдаваа	ТУЗ-ийн дарга	☒ **ирсэн**	☐ ирээгүй
2	Б.Энхбат	Хувьцаа эзэмшигч	☒ **ирсэн**	☐ ирээгүй
3	Б.Даваа-Эрдэнэ	Хуралдаан зохион байгуулах комиссын гишүүн	☒ **ирсэн**	☐ ирээгүй
4	Э.Амгаланбаяр	Хуралдаан зохион байгуулах комиссын гишүүн	☒ **ирсэн**	☐ ирээгүй
5	М.Едигаа	Тооллогын комиссын дарга	☒ **ирсэн**	☐ ирээгүй
6	С.Дөлгөөн	Тооллогын гишүүн	☒ **ирсэн**	☐ ирээгүй
7	С.Баянцогт	Гүйцэтгэх захирал	☒ **ирсэн**	☐ ирээгүй

Хуралдаан даргалагч М.Нямдаваа: Сайн байцгаана уу. Тооллогын комисс ирцийн бүртгэлийг хийж танилцуулна уу.

Тооллогын комиссын дарга М.Едигаа Тооллогын комиссын №1 тогтоолыг танилцуулав. "Алтайн Зам ХК-ийн 2026 оны 10 сарын 06-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд 53973 ширхэг энгийн хувьцаа эзэмшиж буй 2 хувьцаа эзэмшигч оролцож, нийт саналын эрх бүхий 54153 ширхэг хувьцааны 99,667% болж байгааг хуралд оролцогчдод болон хурлын даргад мэдээлсүгэй, нийт саналын эрхтэй энгийн хувьцааны 99,667%-ийн хувьцаа эзэмшигчид хуралд оролцож байгаа тул ирц бүрдсэн гэж үзээд ХЭЭБХурлыг хүчин төгөлдөрт тооцсугай."

Хуралдаан даргалагч М.Нямдаваа: Хуралдаа оролцож байгаа та бүхэнд баярлалаа. Өнөөдрийн хуралдаанд 94,27 хувийн хувьцаа эзэмшигч Ньюпрогресс Групп ХХК-ийг төлөөлөн Маамуугийн Нямдаваа 2026 оны 10 сарын 05-ны өдрийн 26-01/134 тоот итгэмжлэлээр оролцож байна. Мөн хувьцаа эзэмшигч Батчулууны Энхбат оролцож байна. Цахимаар хуралдаанд оролцож байгаа хүн байхгүй байна. Ингээд тооллогын комиссын тогтоолд заасанаар хуралдааны ирц хуульд заасан шаардлагыг хангаж байгаа тул хуралдааныг нээж байна. Энэ удаагийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралдааныг 2026 оны 10 сарын 06-ны өдөр зарласны дагуу танхим болон цахим хэлбэрээр зохион байгуулагдаж байна. Танхимын болон цахим хэлбэрээр зохион байгуулж байгаатай холбоотойгоор хуралдааны зохион байгуулагчаар ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Даваа-Эрдэнэ ажиллана. Мөн танхим болон цахим хосолсон хэлбэрээр зохион байгуулахдаа хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудалаар танхимд ирсэн болон цахимаар оролцох хувьцаа эзэмшигчдэд санал өгөх, асуулт асууж хариулт авах боломжоор ханган ажиллаж байна. Хуралдаан үндсэн дэгийнхээ дагуу явагдана. Хуралдааны материалыг та бүхэнд урьдчилан хүргүүлсэн байгаа. Өнөөдрийн хурлаар Алтайн зам ХК-ийн хэлбэрийг өөрчлөх буюу хязгаарлагдмал хариуцлагатай компани болгох асуудлыг хэлэлцэхээр бид цуглаад байна. Алтайн зам ХК-н нийт энгийн хувьцааны 99,7% нь ашиг сонирхол нэг этгээдүүдэд төвлөрсөн тул

компаний хэлбэрийг өөрчилж ХХК болгох нь зөв гэж ТУЗ үзээд энэжит бус хурлдааныг зохион байгуулах шийдвэр гаргаж та бүхэнд хүргэсэн.
Компаний хэлбэрийг өөрчлөх шийдвэр гарсан тохиолдолд компанид хувьцаа эзэмшигчээр үлдэх эрх нь нээлттэй байгааг дурдаад аль нэг хувьцаа эзэмшигч нь өөрийн хувьцааг компаниас буцаан авахыг шаардсан тохиолдолд компани нэгж хувьцааг 493’970 төгрөгөөр худалдан авхаар ТУЗ-н шийдвэр гарсан. Хараат бус хөндлөнгийн үнэлгээний байгууллагын гаргасан дүгнэлтээр нэгж хувьцааны үнэ цэнийг 432’865,08 төгрөгөөр тодорхойлсон ба тооцоолсон үнэлгээний аргуудаас хамгийн өндөр дүнг сонгож шийдвэр гаргасан. Энэ нь жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хангах зорилготой юм.

Хуралдаан зохион байгуулах комиссын дарга, Гүйцэтгэх Захирал С.Баянцогт: Монгол Улсын хууль тогтоомжууд, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржийн холбогдох журмын хүрээнд компаний хэлбэр өөрчлөх ажлыг зохион байгуулж байгаа. Холбогдох байгууллага, хувьцаа эзэмшигч нарт холбогдох материалуудыг хүргүүлсэн байгаа. Мөн хууль журамд заасны дагуу хурлын зарыг Хувьцаа эзэмшигч нарт 3 удаагийн давтамжтайгаар хүргүүлсэн байна. Мөн хуралд ирэх боломжгүй хувьцаа эзэмшигчийг цахимаар оролцох боломжийг хангаж бэлтгэл ажлыг зохион байгуулсан байгаа.
Хуралдаан даргалагч М.Нямдаваа: Хувьцаа эзэмшигчдэд хэлэлцэх асуудлын мэдээллийг урьдчилан мэдээлсэн ба асуулт санал байхгүй гэсэн тул санал хураалтыг эхлүүлье.

Тооллогын комиссын гишүүн Б.Дөлгөөн: Энэжит бус хурлын Хувьаа эзэмшигчдэд тооллогын комиссоос саналын хуудсыг бөглөх зааварчилгааг танилцуулав. Цахимаар оролцож байгаа хувьцаа эзэмшигчид санал өгөх гэдэг товч дээр дарж үргэлжлүүлэх товчийг дарж, мөн гарч ирсэн баталгаажуулах товч дарснаар санал өгснөөр тэмдэглэх боломж бүрдэнэ. Ингээд Хувьцаа эзэмшигчдээс онлайн болон танхимаар санал авах процесс эхэлж байна. Санал хураалт дэгийн дагуу 10 мин хугацаанд үргэлжилнэ. Та бүхэн дэгийн дагуу бөглөөд бидэнд хураалгана уу.

Товлосон асуудлын хүрээнд санал хураалтыг явуулж тооллогын комиссын №2 тогтоолыг тооллогын комиссын дарга М.Едигаа танилцуулав.

	Хэлэлцсэн асуудал	Тогтоолын төслийн дугаар	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1	Компанийн хэлбэр өөрчлөх тухай	АЗХЭ2026005	53973	0	0

Шийдвэрлэсэн нь: Хувьцаа эзэмшигчдийн энэжит бус хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн шийдвэрээр АЗХЭ2026005 тоот тогтоолыг баталж, Тогтоолыг албажуулах үүргийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /Б.Даваа-Эрдэнэ/-д үүрэг болгов.

М.Нямдаваа: “Алтайн Зам” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн энэжит бус хурал 2026 оны 10 сарын 06-ны өдрийн 14:00 цагт эхэлж, танхим болон цахим хосолсон байдлаар хуралдав. Энэ удаагийн энэжит бус хуралдааныг үүгээр хааж байна. Хуралдаан 2026 оны 10 сарын 06-ны 15:00 цагт өндөрлөв.

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

ТУЗ-ИЙН ГИШҮҮН Б.ДАВАА-ЭРДЭНЭ

ХЯНАСАН:

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ М.НЯМДАВАА